

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны
1/820/ дугаар албан бичгийн хавсралт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 16

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
ЗОРИЛГО.УЛСЫН БҮРТГЭЛИЙН НЭГДСЭН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЖ, ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛЖ, ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ПРОГРАММ ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ. /"Алсын хараа-2050" зорилт 5.3, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.1, Улсын бүртгэлийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө/							
ЗОРИЛТ 1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА.							
1.1	Бүртгэлийн байгууллагын архивын цогцолбор төв байгуулах ажлын зураг, төсөв, бусад баримт бичиг, холбогдох зөвшөөрлийг бүрдүүлэх	Улсын төсөв 500,0 сая төгрөг	Архивын цогцолбор төв байгуулах ажлын зураг, төсөв, бусад баримт бичиг, холбогдох зөвшөөрлийг бүрдүүлэн ажилласан хувь	0	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны "Хөтөлбөр батлах тухай" А/206, байгууллагын даргын 2024 оны А/180 дугаар "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай", 2025 оны А/96, А/97 дугаар "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд УБЕГ-ын архивын зориулалттай барилга байгууламж болон албан хаагчдын орон сууцны барилга, угсралтын ажлыг гүйцэтгэх гэрээг 2025.05.30-ны өдөр "Буянт шарга констракшн"-тай байгуулан, барилгын шав тавих	30

						ёслолыг 2025.06.05-ны өдөр зохион байгуулсан. Архивын зориулалттай барилга нь 1,500 м.кв талбайтай, хоёр давхар (зоорины давхартай) байхаар төлөвлөгдөж, барилгын нийт өртөг 6 тэрбум төгрөгийг гүйцэтгэгч “Буянт Шарга Констракшн” ХХК 100 хувь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэн барьж гүйцэтгэн, 2026 оны IV улиралд хүлээлгэн өгөхөөр төлөвлөн ажиллаж байна. Энэхүү төсөл, хөтөлбөр хэрэгжсэнээр Улсын бүртгэлийн байгууллагын архивын хадгалалт хамгаалалт сайжуурлах, 180 албан хаагчдын амьдралын чанарыг дээшлүүлэх, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чухал ач холбогдолтой юм.	
			Ажлын чанар, гүйцэтгэлийн хувь	0	10	Хөтөлбөрийн хүрээнд Улсын бүртгэлийн байгууллагын архивын байр болон албан хаагчдын орон сууцны барилга угсралтын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэхэд шаардлагатай техникийн нөхцөл болон холбогдох бусад зөвшөөрлийг бүрдүүлэн ажиллаж байна.	
1.2	Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нүүр царайгаар таних системийг нэвтрүүлэх ажлын	-	Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд хүргүүлсэн саналын тоо	0	1	Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд нүүр царайгаар таних системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд хууль эрх зүйн орчин, шаардлагатай тоног төхөөрөмж болон программ хангамжийн тооцоо, судалгааг хийгдэж байна.	30
			Тоног төхөөрөмжийг шинэчлэх бодлогын	0	1	Шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчлэх бодлогын даалгаврын төслийг боловсруулж байна.	

	хүрээнд тоног төхөөрөмжийг шинэчлэх, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх		даалгаврыг боловсруулсан тоо				
1.3.	Улсын бүртгэлийн цахим гэрчилгээг үйлчилгээнд нэвтрүүлэх	-	Цахимаар олгосон эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний тоо	0	20	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим гэрчилгээг олгох хууль эрх зүйн орчинг бий болгох зорилгоор Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 5.1-д заасан өмчлөх эрхийг эрхийн улсын бүртгэлд бүртгэснийг нотолж эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгоно.” гэж холбогдох нэмэлт өөрчлөлтийг тусгуулсан. Азийн хөгжлийн банкны Техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй төсөл нь 2025.06.02-12.30-ны өдрийн хооронд хэрэгжүүлэх бөгөөд эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн системийг шинэчлэн хөгжүүлэх, цахим гэрчилгээ нэвтрүүлэх, сонгогдсон сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг нэвтрүүлэх, ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх зорилготой юм. “ТА10201-МОН: Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах”	30

						төслийн зөвлөх багийг тус банкнаас бие даан сонгон шалгаруулалт хийж, Аствишн ХХК-тай гэрээ байгуулсан. Аствишн ХХК-тай уулзалт зохион байгуулан, программ хөгжүүлэлтийн талаар санал солилцсон.	
1.4.	Иргэний үнэмлэх хэвлэлтийг бүртгэлийн орон нутаг дахь зарим нэгжид хэвлэх дэд бүтцийг бий болгох, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх	-	Хууль эрх зүйн орчинг бүрдүүлэхэд хүргүүлсэн саналын тоо	0	1	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст иргэний үнэмлэх хэвлэх дэд бүтцийг бий болгохоор бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд хууль, эрх зүйн орчны болон хэвлэх төхөөрөмжид иргэний үнэмлэх хэвлэхэд ашиглагддаг программ хангамжийн өөрчлөлт, сайжруулалтын талаар судалгаа хийгдсэн байна.	65
			Дэд бүтцийг бий болгох тоног төхөөрөмжийн бодлогын даалгаврыг боловсруулсан тоо	0	1	Иргэний үнэмлэх хэвлэх дэд бүтцийг бий болгох зорилгоор шаардлагатай техникийн тодорхойлолтыг боловсруулсан.	
1.5.	Төр, хувийн хэвшлийн байгууллагууд цахим тамга, иргэд тоон гарын үсгийг бүртгэлийн үйлчилгээнд таньж баталгаажуулах талаар холбогдох	-	Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал /E-business, E-mongolia/-аар цахим тамга, тоон гарын үсэг ашиглан цахимаар өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авсан тоо	-	30	Төрийн бүтээмжийн үндэсний хорооны ажлын алба, И-Монголиа академи УТҮГ-аас 2025.02.10-ны өдөр уулзалт зохион байгуулж, цахимаар хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлт хүлээн авах үйлчилгээг нэвтрүүлэхээр тохиролцсон бөгөөд 3 дугаар улиралд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /E-Mongolia/-ээр улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс өргөдөл, гомдол, хүсэлтийг цахимаар	-

	арга хэмжээ авах					хүлээн авч шийдвэрлэхтэй холбоотой программын бодлогын даалгаврын боловсруулж хүргүүлсэн. Цахимаар өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авах үйлчилгээ нь E-business 3.0 болон E-mongolia 5.0 хувилбарт хөгжүүлэлт хийгдэхээр хүлээгдэж байна.	
			Цахимаар хүлээн авсан өргөдөл, гомдол, хүсэлтийн шийдвэрлэлийн хувь	-	100	-	
1.6.	Иргэний үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох технологийг хэрэглээнд нэвтрүүлэх	Улсын төсөв 80,0 сая төгрөг	Ойрын зайнаас мэдээлэл солилцох технологийг нэвтрүүлсэн байгууллагын тоо	-	2	Иргэний үнэмлэхэд ойрын зайнаас мэдээлэл солилцох технологийг эмнэлгийн байгууллагаас жор олгох болон Нийтийн тээврийн төлбөрийн хэрэгсэлд ашиглах асуудлаар судалгаа хийсэн. Уг асуудлаар Эрүүл мэндийн байгууллага, Нийслэлийн тээврийн газартай хамтарсан уулзалтыг зохион байгуулж, сүүлийн хагас жилд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	100
1.7.	Улсын бүртгэлийн нэгдсэн санд хандсан хэрэглэгчийн логийн бүртгэлийн программ хангамжийг бий болгох	-	Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санд хандсан хэрэглэгчийн логийн бүртгэлийн программ хангамжийн бодлогын даалгавар боловсруулсан тоо	-	1	Иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн санд нэвтэрсэн, өгөгдөл оруулсан, цахимжуулсан, хайлт хийсэн, боловсруулсан логийн бүртгэлийн программ хангамжийн 3 бодлогын даалгаврыг боловсруулав.	100

1.8.	Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд өгөгдлийн шинжилгээ хийх	-	Үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсэн тоо	12	12	Байгууллагын үйл ажиллагааны дараах судалгаанууд өгөгдлийн шинжилгээ хийсэн байна. Үүнд: - “Их өгөгдөл” ашиглан Аймгийн төвөөс 55км-с ойр байрлах сумдын бүртгэгч нарын 2024 онд хийсэн бүртгэлийн тоо, ачаалалын судалгаа; - Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний ачааллын судалгаанд 2025 оны II улирлын байдлаар дүн шинжилгээ; - Oracle Data Visualization системд хөрөнгө оруулсан улсаар судалгаа; - Өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олголтын үйл ажиллагаанд өгөгдлийн шинжилгээ; - Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /emongolia/-ээр захиалсан гадаад паспортын бүртгэлийн хүсэлтэд өгөгдлийн шинжилгээ; - Төрийн байгууллагад олгож байгаа лавлагаа, мэдээлэл болон орон нутагт шилжилт хөдөлгөөн хийсэн архивын баримтын тоонд өгөгдлийн шинжилгээ.	100
			Шинжилгээний үр дүнд хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	12	12	Мэргэжлийн нэгдсэн холбооны тухай хууль батлагдсантай холбогдуулан улсын бүртгэлийн мэдээллийн сангаас үйл ажиллагааны чиглэлээр судалгаа авах албан хүсэлтүүд ихээр ирэх болсон тул судлан үзэж, Нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал /opendata.gov.mn/-ын нээлттэй өгөгдөл хэсэгт үйл ажиллагааны чиглэлээр хайлт хийх боломжтой болгосон.	

1.9.	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байдалд хяналт тавих	-	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь	99.8	99.8	Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуульд нийцсэн байх талаар УБЕГ, орон нутгийн хэлтсүүд, төрийн өмчит байгууллага нарын шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулалтад сар бүр хяналт тавьж, байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв оруулах, аливаа мэдээллийн баримт нотолгоог бүрэн байршуулах талаар зөвлөмж өгч ажиллав. Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дах заалтыг хэрэгжүүлэн 2025 оны 5 дугаар сарын байдлаар УБЕГ, орон нутаг дахь газар, хэлтэс, төрийн өмч давамгайлсан 1 компани буюу нийт 24 байгууллагын shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг цахим талбарт байршуулж, тайлагнан ажиллав. Шилэн дансны тайланг ХЗДХЯ-нд 2025.06.06-ны өдрийн 7/7762 дугаар албан бичгээр хүргүүлэв.	
			Тайлагнаж, байршуулсан мэдээллийн тоо	3910	3910	2025 оны 05 дугаар сарын байдлаар төсвийн шууд захирагч 23 нэгж нь тус тус 14 буюу 322 мэдээлэл, төвлөрүүлэн захирагч 11 мэдээлэл, төрийн өмч давамгайлсан байгууллага 14 мэдээллийг тус тус байршуулж, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй болно.	
1.10.	Төрийн болон хууль хяналтын	-	Цахимаар үзүүлсэн	-	20	Хууль хяналтын байгууллагуудтай /УЕПГ, УДШ, ЦЕГ, ШШГЕГ/-тай 2025.04.29-05.01-ний өдрүүдэд уулзалт	100

	байгууллагатай цахимаар мэдээлэл, лавлагаа, хуулбар олгох нөхцөлийг бүрдүүлэх.		лавлагаа, мэдээллийн хувь			зохион байгуулж, албан бичиг, лавлагаа мэдээллийг цахимаар солилцох талаар байгууллагын удирдлагууд саналаа илэрхийлж, өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгсөн.Тайлант хугацаанд хууль хяналтын байгууллагад 1,524 албан бичгээр 12,624 лавлагаа, 230 хуулбар 2,408 мэдээллийг тус тус цахимаар (ERP) системээр олгосон байна.	
1.11.	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх үйлчилгээний сэтгэл ханамж, чанар хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор процессын дахин инженерчлэлийн ажлыг эхлүүлэх	-	Эд хөрөнгө, хуулийн этгээд, иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаа сайжирч, гарсан үр дүнгийн хувь	-	Тус бүр 60	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.1.5-д “Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, төрийн өмчийн бүртгэл, газрын хэвлийн баялаг болон газар дээрх баялгийн бүртгэлийг блокчейн технологийг ашиглан гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.” гэж тусгагдсаны дагуу улсын бүртгэлийн үйлчилгээнд блокчейн технологийг ашиглах, нэвтрүүлэх талаар болон бусад үйлчилгээтэй холбоотойгоор УБЕГ-ын дарга, ЦХИХХЯ-ны Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын дарга нар хамтран 2025 оны 03 дугаар сард “Монгол Улсын суурь мэдээллийн сангийн, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-г 4 зорилт, 14 арга хэмжээг гүйцэтгэхээр батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөний 12 дугаар арга хэмжээ болох “Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн гэрчилгээг блокчейн технологи ашиглан баталгаажуулна”	60

						гэж ЦХИХХЯ-аас “блокчейн” технологийг ашиглах программ хангамжийг хөгжүүлэх 850 сая төгрөгийн өртөг бүхий тендер шалгаруулалт зарлаж шалгаруулсан байна. Хуулийн этгээдийн нэрийг хиймэл оюун AI ашиглан баталгаажуулахаар Чимэгэ системс ХХК-тай уулзалт зохион байгуулж, бодлогын даалгавар боловсруулан ЦХИХХЯ-нд хүргүүлээд байна. Иргэний улсын бүртгэлийг хөтлөхөд “Бүртгэлийн дэвтэр”-ийг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас хэвлэн гаргах, бүртгэлийн дэвтэр хялбарчлах талаар судалгааг хийж холбогдох саналыг боловсруулсан.	
ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ.							
2.1.	Улсын бүртгэлийн цахим үйлчилгээг өргөжүүлэх	-	Цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний тоо	123	133	Улсын бүртгэлийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж болох нийт 150 төрлийн лавлагаа, үйлчилгээ нь бүрэн цахимжиж, E-Business болон E-Mongolia системд амжилттай нэвтрүүлж дууссан. Тайлант хугацаанд дараах үйлчилгээг нэмэгдүүлэв. Үүнд: -Хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтын хугацаа сунгах; -Гадаадын хөрөнгө оруулалттай компани шинээр үүсгэн байгуулах; -Тамга, тэмдгийн хяналтын дугаарын лавлагаа; Цаашид Эд хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөх, Эд хөрөнгийн үнэ өөрчлөгдөх, Эд хөрөнгийн хаяг	100

						өөрчлөгдөх, Өмчлөгчийн овог нэр, регистрийн дугаар өөрчлөгдөх, Газрын нэгж талбарын дугаар өөрчлөгдөх, Хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа бүртгэх, Хамтран өөрчлөгдөх 4 төрлийн гэрээ зэрэг нийт 10 төрлийн үйлчилгээг нэмж оруулахаар төлөвлөн ажиллаж ажиллаж байна.	
2.2.	Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин (киоск)-ийн тоог болон киоскоор үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	-	Киоскоор үзүүлэх улсын бүртгэлийн үйлчилгээний төрлийн тоо	26	30	Улсын бүртгэлийн байгууллага, ЦХИХХЯ-тай хамтран төрийн үйлчилгээний Хурдан киоск машинд Улсын бүртгэлийн дөт киоскыг нэгтгэх ажил хийгдэж, систем хөгжүүлэгчээр Гэрэгэ киоск ХХК ажиллаж байна. Тус системийг хөгжүүлж дууссанаар төрийн байгууллага тус бүрдээ киоск машинаар үзүүлдэг үйлчилгээг нэгдсэн байдлаар нэг киоск машинаар үзүүлэх ач холбогдолтой юм.	-
			Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машин /Киоск/-ны нэмэгдүүлсэн тоо	74	80	Дээрх нөхцөл байдлаас үүдэн Улсын бүртгэлийн үйлчилгээний цахим машины тоог нэмэгдүүлэх ажил хүлээгдээд байна.	
2.3.	Улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлэх (автомашин) зөөврийн тоног төхөөрөмжийн программ	Улсын төсөв 180,0 сая/төг	Зөөврийн тоног төхөөрөмжийн тоо	5	30	Тайлант хугацаанд Зөөврийн тоног төхөөрөмж нэмэгдээгүй.	56.6
			Улсын бүртгэлийн хөдөлгөөнт үйлчилгээний тоноглогдсон авто машины тоо	-	1	Улсын хэмжээний байгалийн гамшигт үзэгдэл, осол аваар нийтийг хамарсан гамшгийн үед ОБЕГ-тай хамтран иргэд, хуулийн этгээдэд бүртгэлийн лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлэх Улсын бүртгэлийн хөдөлгөөнт үйлчилгээний тоноглогдсон авто машинтай болох арга хэмжээг УБЕГ-ын дарга, ЦХИХХЯ-	

	хангамжийг сайжруулах, тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх					ны Цахим шилжилтийн бодлого зохицуулалтын газрын дарга нар хамтран 2025 оны 03 дугаар сард "Монгол Улсын суурь мэдээллийн сангийн, цахим шилжилтийг эрчимжүүлэх чиглэлээр 2025 онд хамтран ажиллах төлөвлөгөө"-нд ЦХИХХЯ-наас шийдвэрлэн өгөхөөр тусгагдсан.	
			Улсын бүртгэлийн үйлчилгээг хөдөлгөөнт хэлбэрээр үзүүлсэн иргэдийн тоо	18833	23000	Төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдийн байгаа байршилд нь очин бүртгэлийн үйлчилгээг биеэр болон цахим хэлбэрээр авах боломжгүй зорилтот бүлгийн иргэн (өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, бичиг баримтгүй гэх мэт иргэд), алслагдсан газарт оршин суугч, хүнд өвчтэй иргэд, цэргийн анги, эмнэлэг, асрамжийн газар, хорих байгууллага, боомт, нүүрс тээврийн жолооч, уул уурхайн кемп, их сургуулиуд, ерөнхий боловсролын сургуулиуд, нэг дор олноороо ажилладаг ажиллагсадтай томоохон аж ахуйн нэгжүүдэд улсын бүртгэлийн зөөврийн буюу хөдөлгөөнт үйлчилгээг тайлант хугацаанд нийт 3,382 иргэнд үзүүлсэн байна.	
2.4.	Кибер аюулгүй байдлын тухай хууль, Мөнгө угаах, терроризмтай тэмцэх үндэсний	-	Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн төв байгуулсан тоо	-	1	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны "Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/105 дугаар	100

	зөвлөлийн зөвлөмж болон бусад бодлогын баримт бичгийн хүрээнд байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх					тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын газрын дэргэд Лавлах үйлчилгээний төвийг байгуулсан.	
			Кибер аюулгүй байдал хариуцсан нэгж эсхүл албан тушаалтан нэмсэн тоо	-	1	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны "Улсын бүртгэлийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" А/105 дугаар тушаалаар Хяналт шалгалтын газрын дэргэд Кибер, аюулгүй байдлын хэлтэс байгуулсан.	
			Мөнгө угаах, терроризмтой тэмцэх нэгж эсхүл албан тушаалтан нэмсэн тоо	-	1	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн 2023.09.22-ны өдрийн 03 дугаар зөвлөмжийн дагуу холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хариуцан ажиллах 2 албан хаагчийг байгууллагын даргын тушаалаар томилон, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.	
2.5.	Дундын мэдээллийн санг ашиглан шүүхийн байгууллагын нэгдсэн сангаас иргэний улсын бүртгэл хөтлөхтэй холбоотой мэдээлэл авах үйл	-	Мэдээлэл солилцох боломжтой болсон байгууллагын тоо	2	3	Төрийн мэдээлэл солилцооны "Хур" системээр дамжуулан улсын бүртгэлийн мэдээллийг холбогдох байгууллага албан хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Цагдаагийн ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын холбогдох албан хаагчидтай 2025.04.29-05.01-ний өдрийн хугацаанд хуваарь гарган уулзалтыг зохион байгуулсан. Тус уулзалтын үр дүнд цаашид хийх ажлын	70

	ажиллагааг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах					төлөвлөгөө гарган баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
2.6.	Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагын (ИКАО) стандарт өөрчлөгдсөнтэй холбоотой гадаад паспортын загвар тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах бэлтгэл ажлыг хангах	-	Боловсруулсан шийдвэрийн төслийн тоо	-	1	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025.04.30-ны өдрийн А/148 тоот тушаалаар Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын ДОС 9303 стандартад нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан үндэсний гадаад паспортын загвар, тодорхойлолтод өөрчлөлт оруулах, яаралтай буюу нэг удаагийн цөөн хуудастай аяллын бичиг баримтын загвар төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулж, ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	50
2.7.	Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх	- -	Батлуулсан эрсдэлийн төлөвлөгөөний тоо	-	1	Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн төлөвлөгөөг Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2025 оны 03 дугаар тогтоолын дагуу төлөвлөгөөг шинэчлэн боловсруулсан.	65
			Эрсдэл бууруулсан хувь	8	8	Улсын бүртгэлийн байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийж, цахим санд байршуулахаар бэлтгэж байна.	
2.8.	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх ажлыг зохион байгуулах	-	Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэсэн тоо	1	1	УБЕГ-ын 2025 оны үйл ажиллагаанд "Хэрэглэгчийн үнэлгээ" хийх ажлыг III улиралд хийхээр төлөвлөж байна.	-

2.9.	Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд Улсын бүртгэлийн багц хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх	- -	Боловсруулсан хуулийн төслийн тоо	-	4	Байгууллагын даргын 2025.02.18-ны өдрийн А/19 дугаартай тушаалын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд дараах ажлыг хийв.Үүнд: - Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж байгаатай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн төсөлд ирүүлсэн газар, хэлтсийн саналыг нэгтгэж, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн шигтгэл, түүврийг боловсруулсан. - Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг бэлтгэн хуулийн төсөл тус тус бэлэн болсон. - Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж байгаа бөгөөд хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг улсын бүртгэлд бүртгэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарыг олгох үйл ажиллагаа, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрөл мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг цаасан хэлбэр (эх хувь)-ээр олгох зохицуулалтыг хассанаас үүсэх эрх зүйн үр дагаваруудыг бусад орны эрх зүйн зохицуулалттай харьцуулсан судалгаа хийгдэж байна.	100
------	---	--------	---	---	---	--	-----

			Батлуулсан хууль ТОГТООМЖИЙН ТОО	7	8	-	
2.10	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг харьяалал харгалзахгүй бүртгэх талаар холбогдох арга хэмжээ авах	-	Харьяалал харгалзахгүй бүртгэсэн хуулийн этгээдийн тоо	0	100	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг харьяалал харгалзахгүй бүртгэхээр хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулан боловсруулж байна. Мөн цахим /E-business/-аар дамжуулан ирүүлсэн нэрийн 37,628 хүсэлтийг харьяалал харгалзахгүй шийдвэрлэж, 643 цахим гэрчилгээг харьяалал харгалзахгүй олгосон.	100
ЗОРИЛТ 3. УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛЫГ ХАНГАН, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
3.1.	Улсын бүртгэлийн байгууллагын кибер аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нэгдсэн сүлжээ, программ хангамж системийн аюулгүй байдлыг хангаж, эрсдлийг бууруулах	Улсын төсөв 2,000. 0 сая/тө грөг	Кибер аюулгүй байдлын эрсдэлийн түвшин буурсан хувь	-	5	ТЕГ-аас 2024 онд хийсэн эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу сүлжээний аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээний хүрээнд аймаг, дүүргийн түвшинд сүлжээний нэгдсэн хяналтын систем буюу байгууллагын олон тооны сүлжээний компьютеруудыг нэг цэгээс удирдах, хяналт тавих, аюулгүй байдлыг бүрэн хангах зорилготой хамгийн сүүлийн үеийн технологийн цогц шийдэл "Domain Control"-ийг нэвтрүүлэх чиглэлийг хүргүүлсэн. 2025 онд Хөвсгөл аймгийн УБХ-ийн нийт 45, Баянзүрх дүүргийн УБХ-ийн нийт 88 албан хаагчийн компьютерыг Domain Control системд холбохоор төлөвлөн, И ТИ КРЕАТИВ ХХК-тай Худалдах, худалдан авах гэрээг байгуулан ажиллаж байна.	30
3.2.	Улсын бүртгэлийн	-	Сервер тоног төхөөрөмжийн	0	1	Бүртгэлийн системийн нөөц төвийг газар зүйн өөр байршилд буюу Дархан-	70

	байгууллагын мэдээллийн сангуудыг нөөцлөх дата төвтэй болох		худалдан авалтыг зохион байгуулсан тоо			Уул аймагт байгуулахад нэн шаардлагатай тоног төхөөрөмж, лицензийн жагсаалт (ажлын даалгавар)-ыг боловсруулан "Ухаалаг засаг-2" төслийн нэгжид хүргүүлсэн бөгөөд зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар болон холбогдох баримт бичгийг ЦХИХХЯ болон төсөл хэрэгжүүлэх нэгжид бэлтгэн хүргүүлсэн. "Ухаалаг засаг-2" төслийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хоёр дугаар бүрэлдэхүүн хэсгийн 2.3.2.1 "Улсын бүртгэлийн цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал аюулгүй байдлыг сайжруулах дэд бүтцийг бий болгох" тендерийн зар 2025.04.15-нд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр болон "Ухаалаг засаг-2" төслийн вэбсайт, сошиал хуудсуудад тус тус нийтлэгдсэн. Материал авах хугацаа 2025.05.15-ны өдөр дууссан бөгөөд 2 газраас санал ирсэний дагуу үнэлгээний ажил хийгдэж байна.	
3.3.	Сүлжээний нууцлал аюулгүй байдлыг хангах бүртгэлийн хяналтын систем нэвтрүүлэх	Улсын төсөв 50,0 сая/тө грөг	Сүлжээний нууцлал аюулгүй байдлыг хангах хяналтын систем нэвтрүүлсэн тоо	0	1	Сүлжээний нууцлал аюулгүй байдлыг хангах бүртгэлийн хяналтын систем нэвтрүүлэх ажлыг сүүлийн хагас жилд нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	-
3.4.	Улсын бүртгэлийн	-	Өгөгдлийн сангийн албан	-	1	Улсын бүртгэлийн нэгдсэн сангийн үйлдлийн систем болон өгөгдлийн	50

	нэгдсэн сангийн үйлдлийн систем, өгөгдлийн санг албан ёсны лицензжүүлэх асуудлыг шийдвэрлэх		ёсны лицензийг худалдан авч суурилуулсан тоо			сангийн албан ёсны лицензүүдийн хүчинтэй хугацаа 2025 оны 7, 8 дугаар сард дуусах тул холбогдох лиценз сунгах саналыг ХЗДХЯ-нд хүргүүлсэн.	
3.5.	Улсын бүртгэлийн байгууллагын компьютер, түүний дагалдах техник тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэн, сайжруулах	Улсын төсөв, төсөл хөтөл бөр 2000,0 сая/төгрөг	Техник, тоног төхөөрөмжийн шинэчилсэн тоо	-	100	Азийн хөгжлийн банкттай 2023.10.17-ны өдөр байгуулсан "Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах" техникийн туслалцааны төслийн Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд байгууллагын даргын 2024 оны А/188 дугаар тушаалаар байгуулагдсан "Тоног төхөөрөмж хүлээн авах ажлын хэсэг" 2025.02.07-ны өдөр төслийн нэгжээс 100 ширхэг техник, тоног төхөөрөмжийг (компьютер 50 ширхэг, принтер 25 ширхэг, сканер 25 ширхэг) хүлээн авч, хуваарийн дагуу нэгжүүдэд олгосон. Төслийн хүрээнд 335.0 сая төгрөгийн шаардлагатай лиценз, сүлжээний тоног төхөөрөмжийг хүлээн авч, төслийн бичиг баримт ирэхээр санхүүгийн тайланд тусган бүртгэлжүүлээр ажиллаж байна. ЭХЭУБГ, ХЭУБГ, ХШГ-ын албан хэрэгцээнд шаардлагатай байгаа компьютер, скайнэр, принтерийг шинэчлэх зорилгоор "Төрийн үнэт цаас хэвлэл" ХХК-ийн 2023 оны цэвэр ашгаас	100

						УБЕГ-т хуваарилсан ногдол ашгийн орлогоос тоног төхөөрөмжинд 400,0 сая төгрөгийн төсөв, тооцоо, хэрэгцээний судалгааг гарган байгууллагын удирдлагад танилцуулж, худалдан авалтыг хийхээр ажиллаж байна.	
3.6.	Эрчим хүчний нөөц эх үүсвэр болон серверийн өрөөний хөргөлтийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийх	Улсын төсөв 25,0 сая/төгрөг	Эрчим хүчний нөөц эх үүсвэр болон серверийн өрөөний хөргөлтийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийсэн тоо	0	1	Байгууллагын 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулж, босго үнэ батлах тухай Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолыг үндэслэн УБЕГ-ын "Eaton 93E UPS брэндийн тог баригчийн 1 багц бүрдэл буюу 80 ширхэг 12V 120Ah баттерей нийлүүлэх угсралтын үйлчилгээ хийлгэхээр УБЕГ/20250202017 нээлттэй тендер шалгаруулалтанд Тог баригчийн батарей нийлүүлхээр "ЖИ СИ ЭС ЭМ ТРЕЙД" ХХК шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Серверийн өрөөний хөргөлтийн тоног төхөөрөмжийн гэмтэлд 2025.04.20-ны өдөр засвар үйлчилгээ хийгдсэн.	100
3.7.	Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөлийг сайжруулах	Улсын төсөв	Хадгалалт хамгаалалтын агааржуулалтын системийн хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан хувь	-	1	Дохиолол хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд мэргэжлийн хүнээр галын дачкануудын гэмтэлтлийг засуулж бүх давхар, өрөө, агуулах, гараж, узельд байгаа дохиололын дачкны тоос шороог цэвэрлүүлэх ажлыг Мэдээллийн технологийн газартай хамтран зохион байгуулж, дохиолол суурилуулсан "Тэргэл Тэх" ХХК-тай сар, улирал тутам 880,0 мянган төгрөгөөр үйлчилгээ хийхээр гэрээг байгуулан ажиллаж байна. Агааржуулалтын системийн агаар шүүгч, шүүлтүүрийг	100

						солих ажлын хүрээнд үнийн саналыг судлан ажиллаж байна. "Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хүрээнд 2025 онд хийгдэх ажлын төлөвлөгөө"-нд 23 нэгжид 30,0 сая төгрөгийн төсөвөөр галын дохиолол суурилуулахаар тусгасан боловч улсын төсөвт уг зардалд төсөв, санхүүжилтгүй байгаа тул хийгдэхгүй хүлээгдэж байна. Архивын баримтын хадгалалтыг сайжруулах ажлын хүрээнд Архив, үйлчилгээний цогцолбор төвийн С1 давхарыг архивын зориулалтаар ашиглахаар чөлөөлж НУБГ-ын архивыг баримтыг шилжүүлэн байршуулахад зориулалтын тусгаарлалтын шилэн хана хийж, байгууллагын архивын өрөөний багтаамжийг нэмэгдүүлэн 1 дүгээр байрны сонгуулийн тоног төхөөрөмжийн агуулахыг чөлөөлж архивын нягтруулсан шүүгээ 20 ширхэгийг нэмж суурилуулсан.	
		Улсын төсөв 28,0 сая/төгрөг	Хуулийн этгээдийн архивт нягтруулсан шүүгээ нэмэгдүүлсэн тоо	377	40	Тайлант хугацаанд архивын сангийн хэрэгцээнд 76 ш нягтруулсан шүүгээг нэмж суурилуулан үйл ажиллагаанд ашиглаж байгаагаас Хуулийн этгээдийн архивт 56 ширхэгийг нэмэлтээр тавьж суурилуулсан байна.	
ЗОРИЛТ 4. ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭН, ГАДААД ОРНЫ БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУРШЛАГААС БАЙГУУЛЛАГЫН ОНЦЛОГТ ТОХИРУУЛАН ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
4.1.	Гадаадын болон олон улсын байгууллагатай хамтын	Улсын төсөв, гадаадын зээл	Гадаадын болон олон улсын байгууллагатай харилцах, хамтран ажиллах	2	3	Гадаадын болон олон улсын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх арга хэмжээний хүрээнд дараах ажлыг зохион байгуулав. Үүнд:	100

	ажиллагааг өргөжүүлэх	тусла мж 50.0 сая/тө грөг	баримт бичиг, төслийн тоо		- ОХУ-ын Бүртгэл, Кадастр, зураг зүйн алба РОСРЕЕСТР байгууллагаас 2025.01.13-ны өдрийн 22 дугаартай ирүүлсэн "Санамж бичиг"-ийн албан бус орчуулгыг хийж, санамж бичгийн төслийг 2025 оны 1/4377 дугаартай албан бичгээр ХЗДХЯ-нд хариу хүргүүлсэн. - БНХАУ-ын улсын бүртгэлийн байгууллагатай холбоо тогтоож, хамтын ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүсэлтийг 2025.02.11-ний өдрийн 1/2252 дугаар албан бичгээр ГХЯ-нд, 2025.02.10-ны өдрийн 1/2196 дугаар албан бичгээр БНХАУ-аас МУ-д суугаа элчин сайд Шэнь Миньжуаньд тус тус хүргүүлсэн. - БНХАУ-аас МУ-д суугаа элчин сайдын яамны Эдийн засаг, худалдааны зөвлөх Лиү Жинжитэй 2025.03.11-ний өдөр уулзалт зохион байгуулан, БНХАУ-ын талаас Хятадын бүртгэлийн байгууллагатай холбоо тогтоохын тулд 5-6 байгууллагатай уулзах шаардлагатай бөгөөд шат дараалалтай холбоо тогтоож, айлчлалыг зохион байгуулах боломжтой талаар мэдэгдсэн. - Австралийн Холбооны улсын ижил түвшний бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах ажлын хүрээнд УБЕГ-аас 2025.06.27-07.04-ний өдрүүдэд 9 албан хаагч хамрагдах болсонтой холбогдуулан 2025.05.22-ны өдрийн 1/7119 дугаартай "Дэмжлэг хүсэх тухай"	
--	--------------------------	---------------------------------------	------------------------------	--	--	--

						албан бичгийг "Австралийн Холбооны Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах тухай" удирдамж болон УБЕГ-ын чиг үүрэг, хамтын ажиллагааны хэрэгцээ шаардлагын тухай танилцуулгын хамт, МУ-аас Австралийн холбооны улсад суугаа элчин сайд Д.Даваасүрэнд цахим шуудангаар хүргүүлсэн. - БНЭУ-н ИТЕС (Энэтхэгийн техник, эдийн засгийн хамтын ажиллагаа) болон БНХАУ-ын элчин сайдын яамнаас 2025 онд зохион байгуулагдах сургалтуудын судалгааг хийж, Сингапур, Герман, Швед зэрэг бүртгэлийн системтэй жишиг системтэй улсуудын бүртгэлийн байгууллагуудын онцлог, ялгаатай байдлыг судлан Монголын бүртгэлийн системтэй харьцуулан боломжит санаануудыг судласан.	
			Гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалтын тоо	5	6	ГХЯ-ны Олон талт хамтын ажиллагааны газраас ирүүлсэн албан мэйлийн дагуу уулзалт, сургалтад хамрагдав. Үүнд: - БНТУ-ын Анкара хотноо зохион байгуулагдсан Төв Азийн улсын иргэний бүртгэлийн ажилтны уулзалтад ИУБГ-ын дарга Т.Төгөлдөр 2025.04.15-17-ны өдрүүдэд; - БНХАУ-ын элчин сайдын яам, Хятадын худалдааны яам болон Олон улсын бизнесийн академи (AIBO)-тай хамтран зохион байгуулсан "Нэг бүс Нэг зам" дагуух улс орнуудын төрийн албан	

						хаагчдад зориулсан “Шинэ дэд бүтэц” технологи ба менежмент сэдэвт 14 хоногийн сургалтад ТГ-ын бичиг хэргийн эрхлэгч Э.Цасанчимэг, УБНА-ын лсын бүртгэлийн нэгдсэн архивын архивч Н.Энхчимэг нар 2025.04.17-30-ны өдрүүдэд; - БНСУ-н Олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн санхүүжилтээр тус улсын Шүүхийн харьяа Төрийн албан хаагчдын сургалтын төвөөс “Улсын бүртгэлийн ерөнхий газрын чадавхыг бэхжүүлэх” (2023-2025) төслийн хүрээнд байгууллагын 15 албан хаагч 2025.06.01-14-ний өдрүүдэд тус тус оролцов.	
4.2.	Эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн системийг шинэчлэх ажлыг эхлүүлэх	ADB төсөл	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цахим систем /ePRS/-ийг шинэчлэх хувь	0	80	“ТА10201-МОН: Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах” төслийн хүрээнд эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн системийг шинэчлэн хөгжүүлэх ажлын гүйцэтгэгч багаар Аствишн ХХК шалгарсан бөгөөд хамтын ажил эхэлсэн. Төслийн хүрээнд эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн системийг шинэчлэн хөгжүүлэхэд шаардлагатай ажлын даалгаврын төсөл боловсруулах, ажил гүйцэтгэгчийн гэрээний хэрэгжилт, ажлын гүйцэтгэлд хяналт тавих,	30
		ADB төсөл	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим систем /eRS/-ийг шинэчлэх хувь	0	80		

						шаардлагатай мэргэжил, арга зүйн зөвлөмжөөр хангах, тайлан баталгаажуулах, эх код хүлээн авах, хамтран хэрэгжүүлэгч талуудын уялдаа холбоог хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг УБЕГ-ын даргын 2025 оны А/105 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.	
4.3.	Бүртгэлийн зөрчлийг багасгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомжийн шинжилгээ хийх ажлыг мэргэжлийн хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Улсын төсөв	Хууль тогтоомжийн шинжилгээ хийлгэсэн тоо	0	1	Бүртгэлийн зөрчлийг багасгах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хууль тогтоомжийн шинжилгээ хийх ажлын хүрээнд энэ төрлийн судалгаа, шинжилгээ хийдэг мэргэжлийн байгууллагуудын судалгааг нэгтгэж байгаа бөгөөд сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөн ажиллаж байна.	-
			Шинжилгээний дүн, санал дүгнэлтийг Даргын зөвлөлийн хуралд танилцуулсан тоо	0	1	-	
ЗОРИЛТ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
5.1.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх. /2.6.2.3./	-	Хэрэгжилтийг хангасан хувь	0	70	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, түүнд тусгагдсан холбогдох арга хэмжээг УБЕГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган Хууль зүй, дотоод хэргийн сайдын батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд УБЕГ-ын 2025 оны “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г	100

						2025.04.01-ний өдөр батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	
5.2.	Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч, ашиг хүртэгчийн мэдээллийг нээлттэй мэдээллийн стандартаар ил тод болгож, тогтмол шинэчлэх /4.3.1.2./	-	Нээлттэй мэдээллийн стандартаар ил тод болгосон хуулийн этгээдийн хувь	0	80	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нээлттэй мэдээллийг www.opendata.burtgel.gov.mn , www.opendata.gov.mn , цахим хуудсаар хэвийн төлөвтэй 265125, татан буугдсан 16603, улсын бүртгэлээс хасагдсан 33343 хуулийн этгээдийн мэдээллийг тус тус нээлттэй байдлаар харуулж байна.	100
5.3.	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	Улсын төсөв 10.0 сая төгрөг	АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо	16	18	Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн контент, мэдээлэл, сурталчилгааг аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэн ажиллаж байна. https://www.facebook.com/share/v/1Y1H5tjZ2r/ УБЕГ-ын цахим төв 24/7-н сурталчилгаанд "Товш" аппликэйшний талаарх мэдээллийг хүргэн байгууллагын цахим хуудас, мөн салбар нэгжүүдийн цахим хуудсаар түгээн ажиллаж байна. https://www.facebook.com/share/v/16iYs6EWuY/ Авлигаас урьдчилан сэргийлэх зорилготой Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг ил тод, шуурхай, хүртээмжтэй сурталчлах "Нээлттэй хаалга"-ны өдөрлөг, Гараас	100

						гарт үйлчилгээг аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүд зохион байгуулан ажилласан. Мөн Хуульчдын холбооноос зохион байгуулсан Про боно өдөрлөгт УБЕГ болон 21 аймаг, 9 дүүргийн улсын бүртгэлийн хэлтсүүд оролцон иргэдэд Улсын бүртгэлийн үйлчилгээг гараас гарт үзүүлэн, үйл ажиллагааг сурталчилав. Мөн аймгийн Улсын бүртгэлийн хэлтсүүд албан хаагчдад авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан видео контент өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бүтээж байгууллагын албан ёсны цахим хуудас болон, facebook хуудаст байршуулан ажиллаж байна.	
ЗОРИЛТ 6. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
6.1.	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулах /зорилт 5.7/	-	Албан хаагчдыг чадавхижуулах сургалт зохион байгуулсан тоо	0	1	Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд “Албан хаагчдыг чадавхижуулах сургалт”-ыг III улиралд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	-
			Ижил түвшний бүртгэлийн байгууллагатай хамтран ажиллах замаар туршлага солилцох, сургалтанд хамрагдсан албан хаагчдын тоо	0	1	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний зөвлөл, Олборлох үйлдвэрлэлийг ил тод байдлыг санаачилга, Монгол банкны санхүүгийн мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж байна. Мөн Монголын хуульчдын холбоонд улсын бүртгэгчдийг чадавхижуулах сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулахад дэмжлэг хүсэж 2025.05.27-	

						ны өдрийн 4/7334 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Эцсийн өмчлөгчийн улсын бүртгэл, ФАТФ-ын зөвлөмж сэдэвт сургалтыг III улиралд багтаан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	
ЗОРИЛТ 7.ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА							
7.1.	Байгууллагын 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх	-	Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь	98	100	Байгууллагын 2025 онд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Улсын бүртгэлийн байгууллагын бүтэцийн өөрчлөлтэй холбогдуулан төлөвлөгөө батлагдаагүй. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд тайлант хугацаанд 22 удаагийн сургалт зохион байгуулж, нийт 787 албан хаагч хамрагдсан байна.	100
7.2.	Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"	Улсын төсөв 50.0 сая/төгрөг	Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	92	95	Төрийн албаны тухай хууль, Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 онд хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн батлагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор УБЕГ-ын даргын 2025.01.10-ны өдрийн А/04 дугаар тушаалаар "Байгууллагын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах нөхцөлийг сайжруулахад байгууллагын зүгээс дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд судалгаа хийж, дүгнэлт гаргах, сонгох чиг үүрэг бүхий ажлын хэсэг" байгуулагдан ажиллаж, тусламж дэмжлэг хүссэн албан хаагчдын	100

	боловсруулан хэрэгжүүлэх.					өргөдөл, хүсэлт, аймаг, НУБГ, хэлтсийн албан хаагчдын нийгмийн байдлыг судлан, Нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг, тусламж үзүүлэх шаардлагатай нийт 22 албан хаагчийн судалгааг нэгтгсэн. Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг болон тусгай шалгуур үзүүлэлтийг батлан, ур чадварын нэмэгдлийг 16 албан хаагчдад нийт олгосон. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны “Хөтөлбөр батлах тухай” А/206, байгууллагын даргын 2024 оны А/180 дугаар “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр батлах тухай”, 2025 оны А/96, А/97 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд УБЕГ-ын архивын зориулалттай барилга байгууламж болон албан хаагчдын орон сууцны барилга, угсралтын ажлыг гүйцэтгэх гэрээг 2025.05.30-ны өдөр “Буянт шарга констракшн”-тай байгуулан, барилгын шав тавих ёслолыг 2025.06.05-ны өдөр зохион байгуулсан. Албан хаагчдад зориулсан 2 блок, 16 давхар 180 айлын орон сууцийг 2026 оны IV улиралд хүлээн авахаар ажиллаж байна.	
7.3.	Монгол хэлний тухай хууль,	-	Албан хэргийг кирилл болон	-	100	УБЕГ-ын хэмжээнд 2025.06.06-ны өдрөөс эхлэн ХЗДХЯ-нд явуулж байгаа	100

	Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж эхлэх		үндэсний хос бичгээр хөтөлсөн хувь			албан бичгийг "Кимо" буюу "Болорсофт" компанийн хөгжүүлсэн "Болорсофт" программыг (https://kimo.mngl.net/) ашиглаж хос бичгээр хөтлөж байна.	
7.4.	Улсын бүртгэлийн байгууллагын зөрчил гаргасан алба хаагчдад сахилгын болон ёс зүйн хариуцлага хүлээлгэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авах	-	Хариуцлага хүлээлгэсэн хувь	0	100	Тайлант хугацаанд нийт 61 албан хаагч сахилгын шийтгэл болон ёс зүйн хариуцлага хүлээсэн байна. Үүнээс Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтад заасан "Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах"-4, 48.1.2 дахь заалтад заасан "Нийт ажигтанд зарлах хэлбэрээр сануулах"-18, 48.1.3 дахь заалтад заасан "Албан тушаалын цалингийн хэмжээг бууруулах"-33, 48.1.4 дэх заалтад заасан "Төрийн албанаас халах"-5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3 дахь заалтад заасан "Байгууллагын албан хаагчдын өмнө нээлттэй сануулах"-1 албан хаагчид тус тус арга хэмжээ авч ажиллав.	100
7.5.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/116 дугаар тушаалаар	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100	"Эрдэмт Монгол" зорилтот арга хэмжээний хүрээнд 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын ЭЕШ өгөх 51 хүүхдийн судалгааг гарган ДХИС-ийн багш нарын цахим сургалтаар заах монгол хэл, англи хэл, математик, нийгмийн ухааны хичээлд	100

	баталсан "Эрдэмт Монгол" зорилтот арга хэмжээний төлөвлөгөөний эхний шатны хэрэгжилтийг хангах					2025.04.15-05.29-ний өдөр хүртэл Монгол хэл, математик, англи хэл, нийгмийн ухааны 4 төрлийн хичээлээр ЕЭШ-тад бэлтгэх сургалтад орон нутгийн албан хаагчийн төгсөх ангийн нийт 47 хүүхэд цахим сургалтад хамрагдсан. Мөн багшлах эрхийн сургалтад хамрагдах хүсэлтэй 18 албан хаагч болон түүний гэр бүлийн гишүүдийн судалгааг гарган 2025.03.03-ны өдөр цахим шуудангаар ХЗДХЯ-нд хүргүүлсэн. УБЕГ-ын албан хаагчдын ЕБС-ийн 12 дугаар анги төгсөх хүүхдүүдийн судалгааг гарган 7 хоног бүрийн Бямба гаригт 11.00-13.00 цагийн хооронд спорт зааланд соёл хүмүүжлийн арга хэмжээ зохион байгуулж, И-Монгол Академийн "Хиймэл оюун ухаан AI"-ын сургалтад хамруулж байна.	
7.6.	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/110 дугаар тушаалаар баталсан "Хамгийн чухал нь" зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх	-	Үзлэг, онолшилгоонд алба хаагчдын хамрагдсан хувь	-	100	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын орон нутаг дахь салбар, нэгжид ажиллаж байгаа албан хаагчид, тэдний насанд хүрсэн гэр бүлийн гишүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрт илрүүлэг хийх зорилтод арга хэмжээг дэмжин ажиллах, алба хаагчдаа бүрэн хамруулах ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын байдлаар Архангай аймгийн УБХ 20, Баян-Өлгий аймгийн УБХ 32, Говь-Алтай аймгийн УБХ "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд 21, Дархан-Уул аймгийн УБХ 22, Дундговь аймгийн УБХ 29, Дорнод аймгийн УБХ	100

						31, Дорноговь аймгийн УБХ 31, Дорнод аймгийн УБХ 34, Баянзүрх дүүргийн УБХ 20, Орхон аймгийн УБХ 51, Өмнөговь аймгийн УБХ 34 албан хаагч (гэр бүлийн гишүүд)-ийг тус тус эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ оношлогоонд хамруулсан байна. Мөн Хууль зүйн салбарын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт Төрийн албан хаагчийн эмнэлгийн эмч, албан хаагчдын унааны зардал болох 9,5 сая төгрөгийн шийдвэрлэсэн. Тус аяны хаалтын арга хэмжээ 2025.06.10-ны өдөр зохион байгуулагдаж байгууллагын удирдлага болон албан хаагчдын төлөөлөл оролцон Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 6 эмч, мэргэжилтнүүдийг УБЕГ-ын "Жуух бичиг"-ээр шагнаж урамшуулсан.	
Нийт							81